



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 541

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, 57,220,710.00 (тавин долоон сая хоёр зуун хорин мянга долоон зуун арван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Баяртготох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

000235-

D:\Huraldaanii material\2018 on\2018.10.23\Togtool.docx

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

**ХОВД АЙМАГ ДАХЬ БУСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАТСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуруимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл ертөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Сэргээн худалдах доод үнэ (төгрөг)
1	Уаз 220692-033, 43-63 ХОА, тусгай, хөдөлгүүр-90001722, арагл-90495917	2009.01.01	365 300	16 236 000,00	16 236 000,00	-	-	1 500 000,00
2	Донгфен, 45-69 ХОА, суудлын, хөдөлгүүр-09007096, арагл-LJNMFMBXX9N049714	2009.11.14	295 300	40 984 710,00	40 984 710,00	-	-	3 000 000,00
	<b>НИЙТ ДҮН</b>	-	-	<b>57,220,710.00</b> (тавин долоон сая хоёр зуун хорин мянга долоон зуун арван)	<b>57,220,710.00</b> (тавин долоон сая хоёр зуун хорин мянга долоон зуун арван)	-	-	<b>4,500,000.00</b> (дөрвөн сая таван зуун мянган)